

УЛАМЖЛАЛТ АНАГААХ УХААНЫ ХАЛУУН ЖИН
ЗАСАЛ ЭМЧИЛГЭЭНД ОРЧИН ҮЕИЙН ТЕХНОЛОГИ НЭВТРҮҮЛЭХ НЬ

Түмэнбат Цэцэгдарь, Түдэв Ариунжаргал, Дашжамц Шагдарсүрэн, Зоригт Лхагвасүрэн,
Шарав Болд, Лхагвадорж Түдэвдагва
Уламжлалт Анагаах Ухааны Тэнхим, Эм Зүйн Шинжлэх Ухааны Их Сургууль,
Улаанбаатар хот, Монгол Улс
*цахим шуудан: ltudevdaagva@gmail.com

INTEGRATION OF MODERN MEDICAL TECHNOLOGY INTO TRADITIONAL MEDICINE
HOT COMPRESS THERAPY

Tsetsegdari Tumenbat, Ariunjargal Tudev, Shagdarsuren Dashjamts, Lkhagvasuren Zorigt,
Bold Sharav, Tudevdaagva Lkhagvadorj
Department of Traditional Medicine, Mongolian University of Pharmaceutical Sciences,
Ulaanbaatar, Mongolia
*email: ltudevdaagva@gmail.com

Abstract

Introduction: This study aimed to explore the feasibility of integrating modern technology into traditional medicine hot compress therapy. In Mongolian traditional medicine, hot compress therapy is a widely used method for effectively treating cold-related disorders and for improving blood circulation and metabolism. A variety of traditional materials are commonly employed, including salt, river stones, wall-growing moss, soil from rodent burrows, pigeon droppings, and oil residues.

Methods: Using descriptive and literature-based research methods, these materials were systematically reviewed and summarized, with particular attention to the characteristics of traditional heating techniques. In parallel, the applicability of modern heating technologies such as electric heating wires, plug-in heating devices, silver-coated thermal insulation materials, and soft containment pouches—was experimentally evaluated for use in hot compress therapy.

Conclusion: The results demonstrated that combining traditional hot compress materials with modern heating devices can enhance safety, ease of use, and thermal stability. In conclusion, integrating traditional hot compress therapy with modern technology has significant potential to improve therapeutic efficacy, facilitate the development of standardized treatment protocols, and promote broader clinical application in practice.

Key word: Modern technology, hot compress, cold-related disorders

Үндэслэл

Анагаах ухааны дөрвөн үндэст жин заслыг сэрүүн болон халуун хэмээн ангилж, тухайн өвчний шинж, үе шат, бие махбодын байдалд тохируулан хэрэглэхийг тодорхой заасан байдаг¹. Түүнчлэн “өвчний хатгалгыг даруйд дарах эрхн засал нь жинлэхүй буй”¹ хэмээн тэмдэглэсэн нь жин заслын эмчилгээний ач холбогдол, клиник хэрэглээг онцолсон байна. Халуун жин заслын хэрэглэгдэхүүн, аргачлалын талаар Лувсанчойнпилийн Нандин эрдэнийн шимийн хураангуй, Сүмбэ хамбын Дөрвөн рашаан, Дармо

маарамба Лувсанчойдагийн Зарлигийн эрхэст харанхуйг арилгагч зул зэрэг эх сурвалжуудад дэлгэрэнгүй өгүүлсэн байдаг²⁻⁴. Эдгээр сударт давс, усны чулуу, архины шаар, тоосго, шавар сав, хонины хоргол зэрэг байгалийн гаралтай материалуудыг халааж жигнэх, жин тавих аргуудыг өвчний үед өргөн хэрэглэж ирснийг тэмдэглэсэн нь халуун жин засал нь олон зуун жилийн турш туршлагаар батлагдсан эмчилгээний арга болохыг илтгэнэ^{2,3}. Гэсэн хэдий ч уламжлалт

халуун жин заслын үед дулааныг жигд хадгалах, температурын түвшнийг хянах, түлэгдэх эрсдэлээс сэргийлэх, эмчилгээний нөхцөлийг стандартчилах зэрэг асуудал практикт тулгарсаар байна. Орчин үед уламжлалт анагаах ухааныг орчин үеийн шинжлэх ухааны нотолгоо, технологийн дэвшилтэй уялдуулан хөгжүүлэх шаардлага нэмэгдэж байгаа бөгөөд энэ хүрээнд халуун жин заслын уламжлалт аргачлалыг орчин үеийн халаах технологитой хослуулах нь эмчилгээний аюулгүй байдал, үр нөлөөг дээшлүүлэх чухал боломж гэж үзэж байна. Тиймээс Уламжлалт анагаах ухааны халуун жин заслын хэрэглэгдэхүүн болон орчин үеийн технологи ашиглан эмчилгээний нөхцөлийг стандартчилахад түлхэц болгохоор тус сэдвийг сонгон авлаа.

Судалгааны ажлын зорилго

Уламжлалт анагаах ухааны халуун жин засал эмчилгээнд орчин үеийн технологийг нэвтрүүлэх боломжийг гаргаж ирэх

Судалгааны ажлын зорилт

1. “Анагаах ухааны дөрвөн үндэс” болон тайлбар зохиолуудаас халуун жин заслын уламжлалт хэрэглэгдэхүүн, аргачлалыг тодруулах.
2. Засал эмчилгээнд орчин үеийн технологийг хослуулах боломжийг гаргаж ирэх

Судалгааны хэрэглэгдэхүүн ба арга арга зүй Судалгааны материалд дараах сурвалж бичгийг ашиглав. Үүнд:

1. Анагаах ухааны дөрвөн үндэс. УБ, 2020 Ш.Болд
2. Лувсанчойнпил. Нандин Эрдэнийн шимийн хураангуй УБ 2001 М.Амбага, Б.Саранцэцэг
3. Ишбалжир (Сүмбэ хамба). Дөрвөн рашаан (Рашааны цагаан шүүдэр). Өвөр Монголын хэвлэлийн бүлэг. 2015
4. Дармо маарамба Лувсанчойдаг “Зарлигийн эрхэст харанхуйг арилгагч зул” Өвөр Монголын хэвлэлийн хороо 2015

Судалгааны арга, аргачлал

1. Эх бичиг, Сурвалж бичиг судлалын арга- Бид эх бичиг, сурвалж бичиг судлалын аргаар

Анагаах ухааны дөрвөн үндэс түүний тайлбар зохиолуудаас сонгон авч тэдгээрийн бүтэц агуулга, жин заслын тайлбарыг задлан шинжилж судална.

2. Харьцуулах арга – Уламжлалт халуун жин заслын уламжлалт аргыг орчин үеийн халаах технологитой хослуулахдаа дулаан дамжуулах чадвар, температурын тогтвортой байдал, дулаан хадгалах хугацаа, хэрэглэхэд аюулгүй байдал, хэрэглэхэд хялбар байдал зэрэг үзүүлэлтээр харьцуулан үнэлсэн. Халаалтын температурыг 55-60°C, 20–30 минутын турш тогтмол дулааныг жигд хадгалах боломжийг туршсан.
3. Магадлан жагсаах арга- Уламжлалт анагаах ухааны эртний тайлбар зохиолуудыг он цагийн дагуу жагсааж түүнээс уламжлалт анагаах ухааны жин заслын бүлэгт байх халуун жин заслуудыг жагсааж гаргасан.

Судалгааны ажлын үр дүн

1. Уламжлалт халуун жин заслын аргыг судалж давс, усны чулуу, газрын хөвх, хулганын шороо, хөх шувууны баас, морины баас, тоосго, шавар сав, тостой эсгий, шилүүс, чонын үс, хайрмаг чулуу, хар тосны шаар, өөхөн цагаан чулуу, архины шаар, хонины хорголыг халааж ашиглах боломжтойг тогтоосон.

Анагаах ухааны дөрвөн үндэст дурдагдсан жин заслын хэрэглэгдэхүүнийг тайлбар зохиолоос тодруулахад:

Газрын хөвх:

“Нандин эрдэнийн шимийн хураангуй”: Хуучин хэрмэнд наалдаж ургасан шороо “Зарилгийн эрхэст харанхуйг арилгагч зул”: Хуучин хүрээ буюу хэрмэн дээр хур бороо орж тогтсон зүлэг шиг газрын хөвд

Хулганы нүхний шороо:

“Зарилгийн эрхэст харанхуйг арилгагч зул”: Дорно зүг хандсан хулганы нүхний шороо

Хөх шувууны баас:

“Нандин эрдэнийн шимийн хураангуй”: Тагтааны баас

Хар тосны шаар:

“Нандин эрдэнийн шимийн хураангуй”:
Гүнждийн тосны шаар

Өөхөн цагаан чулуу:

“Зарилгийн эрхэст харанхуйг арилгагч зул”:
Нүхтэй цагаан чулуу

“Дөрвөн рашаан”: Хорхой идсэн өөхөн цагаан чулуу

Хайрмаг чулуу:

“Зарилгийн эрхэст харанхуйг арилгагч зул”:
Асга хадны ёроолд байдаг хумсан төдий хайрга чулуу гэж тайлбар зохиолуудаас тодруулав.

- Орчин үеийн халаах технологиос халаагч утас, залгууртай халаагч, мөнгөлөг дулаан тусгаарлагч материал, зөөлөн даавуун уут зэргийг сонгон ашиглах боломжтой гэж үзэв. Эдгээр төхөөрөмжүүд нь температурыг 55-60°C, 20–30 минутын турш тогтмол дулааныг жигд хадгалах, тогтвортой барих, түлэгдэх эрсдэлийг бууруулах давуу талтай байв.




Figure 1. Electrical heating pad



Figure 3. Silver foil



Figure 2. Heating pad cover




Figure 4. Charger

Судалгааны ажлын дүгнэлт

Судалгааны үр дүнгээс үзэхэд уламжлалт анагаах ухааны халуун жин заслыг орчин үеийн халаах технологитой хослуулах бүрэн боломжтой байна. Орчин үеийн төхөөрөмжүүдийг ашигласнаар дулааны тогтвортой байдал сайжирч, аюулгүй хэрэглээ нэмэгдэн, эмчилгээний нөхцөлийг стандартчилах боломж бүрдэж байна. Энэхүү судалгаа нь уламжлалт жин заслын аргыг орчин үеийн технологийн дэвшилтэй уялдуулан хөгжүүлэх суурь судалгааны ач холбогдолтой гэж дүгнэв.

Хэлцэмж

Уламжлалт халуун жин заслын хэрэглэгдэх материал, халаах аргачлалын онцлогийг орчин үеийн технологитой уялдуулан судлах нь эмчилгээний аюулгүй байдал болон үр нөлөөг нэмэгдүүлэх ач холбогдолтой байна. Орчин үеийн физик эмчилгээний дулаан эмчилгээний аргуудтай харьцуулахад халуун жин засал нь эдийн цусан хангамжийг сайжруулах, булчингийн агшилтыг сулруулах, өвдөлтийн мэдрэмжийг бууруулах физиологийн үйлчлэлтэй болох нь ажиглагдаж байна. Мөн тогтвортой температур хадгалах боломжтой төхөөрөмж ашигласнаар түлэгдэх эрсдэл буурч, эмчилгээний стандарт нөхцөлийг бүрдүүлэх боломжтой болсон. Иймд уламжлалт халуун жин заслын аргыг орчин үеийн технологитой хослуулах нь практик хэрэглээ болон цаашдын клиник судалгаанд чухал ач холбогдолтой гэж үзэж байна.

Ном зүй

1. Болд Ш., Анагаах ухааны дөрвөн үндэс. УБ, 2020 х.х 461
2. Амбага М., Саранцэцэг Б., Нандин Эрдэнийн шимийн хураангуй УБ 2001 х.х 156
3. Ишбалжир (Сүмбэ хамба)., Дөрвөн рашаан (Рашааны цагаан шүүдэр). Өвөр Монголын хэвлэлийн бүлэг. 1998 х.х 426
4. Дармо маарамба Лувсанчойдаг., “Зарлигийн эрхэст харанхуйг арилгагч зул” Өвөр Монголын хэвлэлийн хороо 2015 х.х 597